

СУРАХ БИЧИГ, ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛАХ ТАЛААРХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ

PREPARE TO METHODOLOGICAL RECOMMENDATION OF THE HANDBOOK AND WORKBOOK



Ц.ГАНБОЛД
Доктор, профессор

GANBOLD TS.
Professor, doctor (Ph.D)

Товч агуулга: Хууль сахиулахын их сургуулийн сурах бичиг, гарын авлагад тавигдах шаардлага, стандартыг боловсруулсан хэдий ч арга зүй, үнэлгээний асуудлыг тодорхой болгох зорилготой. “Зохиолын хулгайн” асуудлыг багш, судлаачдад онцгой асуудал болгон судлахыг зөвлөж байна. Мөн дэвшүүлэн тавьж буй асуудлаар өөрийн санал, дүгнэлтийг тусгасан болно.

Abstract: Workbook of Law Enforcement University to be released requirement of handbook, standart even if processed, method, determination to be certain of assement problem.

I recommend to study of problem Plagiatism to be researchers special. I projected own suggestion and conclusion.

Түлхүүр үгс: Сурах бичиг, гарын авлага, ялгаа, онцлог, плагиат, зохиолын хулгай, санал.

Key words: Workbook, handbook, difference, feature, plagiat, suggestion.

Их, дээд сургуулийн багшид тавигддаг үндсэн шаардлагуудын нэг нь судалгаа шинжилгээний ажил хийх, ном, сурах бичиг, гарын авлага боловсруулах, бүтээл туурвилтай байх асуудал байдаг.

ХСИС-ийн багш нар эрдэмжиж, залуужиж байгаа нь сайн тал хэдий ч багшийн ажлын туршлага, ур чадвар, бүтээл туурвилын чансаа гэдэг асуудал бол багшлах цаг хугацааны туршид бүрэлдэн тогтож, төлөвшин хөгжиж байдаг насан туршийн, урт удаан хугацааны үйл явц байдаг.

ХСИС-ийн багш нарын дунд жил бүр уламжлал болгон явуулдаг буудлагын тэмцээний сүүлийн хоёр жилийн дүнгээс гүйлгээ дүгнэлт хийхэд арын шугам дээр “өвгөн, эмгэн”-ээрээ цоллуулж

байсан доктор, профессор, хурандаа П.Баттогтох, О.Цэцэгмаа нар гар бууны төрөлд аваргын байраа хоёронтоо хамгаалж байх жишээтэй. Энэ бол дээр дурьдсан туршлага, чадвартай холбоотой амьд, бодит жишээ болой.

Их сургуулиас сурах бичиг, гарын авлагад тавигдах стандарт, шаардлагыг боловсруулан мөрдүүлж байгаа бөгөөд энэ шаардлагыг арга зүйн хувьд л тодорхой болгох зорилготой.

Хийж бүтээх, туурвих, цогцлоох ирмүүн хүсэл эрмэлзлэлээр дүрэлзэж яваа залуу, халуун мэргэжил нэгт эрхэм багш нартаа сурах бичиг, гарын авлагын зааг ялгаа, онцлог, тавигддаг шаардлага болон залуу судлаач, эрдэмтдийн жигшиж явах үйлдэл болох зохиолын хулгайн талаар бяцхан зөвлөмж



Хууль сахиулахуй

бэлтгэснээ хуваалцах гэсэн юм.

Сурах бичигт тавигдах шаардлага

1.Ном, сурах бичиг хоёрын ялгаа

Ном бол хүн төрөлхтний өмнөх үеийн мэдлэг, туршлагыг хадгалах, хойч үед дамжуулах хэрэгсэл бөгөөд тэдгээр мэдлэг, туршлагын мэдээллийн загвар юм. Харин сурах бичиг бол тэр мэдлэг, туршлагыг зөвхөн мэдээлэх бус сургах, сурснаа амьдрал ахуйдаа хэрэглэх, буруу зөв сурснаа шалган, алдаа дутагдлаа засаж чаддаг болгох зорилготой сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны загвар юм.

2.Сурах бичиг гэж юу вэ? Сургалтын зорилго, зорилт, агуулга, сургах үйл явцын боловсруулалт ба сонголт, сургалтын хэлбэр зэрэг сурган хүмүүжүүлэх тогтолцооны дөрвөн гол элементийг тусгасан мэдээллийн иж бүрэн загварыг сурах бичиг гэдэг.

3.Сурах бичгийн үүрэг

- Сурах бичиг бол сурагчид бие даан ажиллах хэрэгсэл. К.Д.Ушинский

- Сурах бичгийг хэн ч аваад үзсэн ойлгогдохоор, бие даан сурч болохоор зохиох ёстой. Н.К.Крупская

-Сурах бичиг багшийн үүргийг бүхэлд нь буюу эсвэл ямар нэг хэмжээнд гүйцэтгэхээр байх ёстой. Ф.Талызина

-Сурах бичиг багшийн гарт байгаа нэг хүчтэй хэрэгсэл мөн. Харин сургалтын процессыг бие даан удирдах хэрэгсэл биш. Я.А.Коменский

Оросын судлаачид:

- мэдээллийг зохистой дамжуулах;
- суралцагчдад шинжлэх ухааны болон логик сэтгэлгээ төлөвшүүлэхэд нөлөөлөх;

- мэдлэгээ бататгаж өөрийгөө хянах;
- бие дааж мэдлэг эзэмших;
- олон төрлийн мэдээллийг багцлах, нэгтгэж, зохистой хорших;

- суралцагчийн онцлогт тохируулах, хүмүүжүүлэх, хөгжүүлэх үүргийг онцлон үздэг байна.

Баруун Европын судлаачид

/В.Айзенхут, М.Бауман/:

- мэдээлэл өгөх;

- танин мэдэх үйл ажиллагааг зохион байгуулах;

- сурах сэдэл тэмүүлэл өгөх;

- сургалтын үр дүнг бататгах;

- мэдлэг, чадварын хоорондын холбоог тогтоох;

- сурах үйлийг ашигтай, цагийн хувьд хэмнэлттэй явуулах үүргийг онцолж байгаа нь ерөнхийдөө ижил төстэй байна.

4.Сурах бичгийн хэв шинж


I хэв шинж. Мэдлэг, түүнийг эзэмших арга, үйл ажиллагааны аргыг багтаасан байна. Асуулт даалгаврын бүтэц нь үндсэн эхийг бодвол гол бус үүрэгтэй байна. Асуулт даалгавар нь үндсэн эхийн дараа өгөхөөс гадна, явцад, эхэнд нь өгөх арга хэрэглэсэн байна. Энэ хэв шинжид байгаль, нийгмийн ухааны сурах бичгүүд хамрагдана.

II хэв шинж. Үйл ажиллагааны туршлага эзэмшүүлэхэд голлон анхаарч түүний үе шат бүрийг нарийвчлан тусгасан сурах бичгүүд. Загвар, ухагдахууны хэлбэртэй бичил өгүүллүүд голлох ба хэт онолдсон том эхүүд бага байна. Асуулт даалгаврын системд сэтгэхүйн бодлого, дасгалууд том байр суурь эзэлнэ. Хичээл бүрээр тодорхой бүтцэд оруулж бичсэн байх ба эцэст нь практик үйл ажиллагааны хүссэн түвшингийн ач холбогдлыг нэгтгэн дүгнэсэн дүгнэлт оруулсан байна. Хөдөлмөр техник, эрүүл мэнд, гадаад хэлний сурах бичгүүд орно.


III хэв шинж. Гоо сайхны таашаал, мэдрэмж, урлагийн үнэт зүйлд хандах зөв хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн сурах бичгүүд. II хэв шинжийн сурах бичгийн адил үйл ажиллагааг гол бүрдэл болгох боловч ухаарал, бүтээлч бясалгал, сэтгэл хөдлөлийн аястай даалгаврууд голлох үүрэгтэй /дүрслэх урлаг, гоо зүй, уран зохиолын сурах бичгүүд/.



МОНГОЛ
УЛСЫН
ХҮҮРИЙН
ХӨГӨӨ
МОНГОЛ



5.Сурах бичиг бол сурган хүмүүжүүлэх тогтолцооны загвар мөн.



6.Сурах бичгийн дасгал, даалгаврын тогтолцооны загвар

Сургалтын зорилгын үндсэн шалгуур үзүүлэлтүүд	Дасгал, даалгаврууд
1.Мэдлэг Үзсэн зүйлээ тогтоож, сэргээн санаж чаддаг байна.	Суралцагч -нэр томъёо -үндсэн ойлголтууд -тодорхой баримтууд -дүрэм зарчим -арга, үйл явцыг мэдэх, тэдгээрийг сэргээн санах даалгавар гүйцэтгэнэ.
2.Ойлголт -үгээр илэрхийлсэн мэдлэгийг тооны хэлд шилжүүлэх, зураг, бүдүүвчээр харуулах гэх мэт мэддэг зүйлээ нэг хэлбэрээс нөгөөд шилжүүлэх -мэддэг зүйлээ товч өөрийн үгээр илэрхийлэх зэрэг байх бөгөөд зөвхөн мэдэхээс илүү өндөр түвшин юм.	Суралцагч -дүрэм, зарчмыг ойлгох, тайлбарлах -бүдүүвч, хүснэгтийг таайлбарлах -үгээр илэрхийлсэн мэдлэгийг тооны хэлээр илэрхийлэх -өөрийн үгээр товч илэрхийлэх -товч дүгнэлт гаргах даалгавар гүйцэтгэнэ.



МОНГОЛ
УЛСЫН
ХУУЛЬ
САХИУЛАХ
УНДГАР
СЭМЖ

3.Хэрэглээ Мэдлэгээ тодорхой, шинэ нөхцөлд хэрэглэх. Энэ нь мэддэг, ойлгосон байхаас илүү өндөр түвшин	Суралцагч -хууль, дүрэм, онолыг шинэ нөхцөлд хэрэглэх, практикт хэрэглэх -зөв хэрэглэх аргыг үзүүлэх даалгавар гүйцэтгэнэ.
4.Задлан шинжлэх Бүхэл зүйлийг түүний бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваах, хэсгүүдийн хоорондох холбоог тодорхойлох, нэг нэгдмэл зүйл болгож байгаа зарчмыг ухаарах. Энэ нь мэдэх, ойлгох, хэрэглэх түвшингээс илүү өндөр оюуны үйл шаардана.	Суралцагч -бүрдэл хэсгүүдийн онцлог, ялгаа, ач холбогдол, тэдгээрийн дэс дарааг тодорхойлох -бүхэл зүйлийг бүрдэл хэсгүүдэд салган хуваах, ангилах даалгавар гүйцэтгэнэ.
5.Нэгтгэн дүгнэх Бүрдэл хэсгүүдээс нэгэн цул бүхэл зүйл (илтгэл, мэдээллийн хялбаршуулсан бүдүүвч) бүтээх	Суралцагч -зохион бичлэг хийх -туршилтын төлөвлөгөө хийх -үүдэд салган хуваах, ангилах даалгавар гүйцэтгэнэ.
6.Үнэлгээ Ямар нэгэн зүйлийг тодорхой зорилгоор үнэлэх, ингэхдээ дотоод бүтэц, логикийн болон гадаад шинж чанарыг гаргах шалгуур хэрэглэх, шалгуурыг суралцагч өөрөө гаргах буюу бэлнийг ашиглаж болно. Энэ нь өмнөх бүх түвшингээс илүү өндөр үнэлгээ шүүлтийн чадварыг нэмсэн түвшин.	Суралцагч -бичмэл эхийн бүтэц логикийг үнэлэх -байгаа баримт, дүгнэлт хоёрын холбоог үнэлэх -тухайн зүйлийн дотоод, гадаад шинжийг гаргах үйл ажиллагааны аргачлалыг үнэлэх зэрэг даалгавар гүйцэтгэнэ.

Оюутан, сонсогчдын бие дааж судлах гарын авлагын тухай

Бие дааж судлах гарын авлага гэдэг нь суралцагчид бүхлээр нь буюу хэсэгчилсэн байдлаар уншиж судлахад зориулж, тусгайлан бэлтгэсэн хэвлэмэл ном юм. Энэ нь уламжлалтай ном товхимол, гарын авлагаас ямар ялгаатай болохыг авч үзье.

Уламжлалт ном товхимол, сурах бичиг	Бие дааж судлах гарын авлага
• Зорилт нь их ерөнхий байна.	• Зорилт нь оновчтой тодорхой байна.
• Уг материалыг судлах зөвлөмж бараг байдаггүй.	• Гарын авлагыг хэрхэн судлах зөвлөмжтэй байна.
• Лекцийг бараг тэр чигээр нь хэвлэсэн байдаг.	• Суралцагчтай харилцсан, ярьсан байдлаар бичигддэг.
• Хэнд хандаж байгаа нь тодорхойгүй, хөндий өнгө аястай.	• Суралцагч руу хандсан өөриймсөг өнгө аястай.
• Суралцагчийг идэвхжүүлэх ажил бараг байдаггүй, Хааяа бүлэг сэдвийн дараа цөөн асуулт, даалгавар өгсөн байдаг.	• Сэдэв бүрийн дараа тэдгээрт тохирсон, шинэ мэдлэгийг бататгах сонирхолтой ажлууд өгсөн байна.
• Цөөн хэдэн гарчигт бүх зүйлийг багтаасан байна.	• Агуулгын олон жижиг хэсэгт хувааж, тус бүрт гарчиг, тэмдэг тавьсан байна.
• Уншихад хялбар дөхөм болгох талаар бараг анхаардаггүй.	• Уншихад хялбар ойлгомжтой байна.



• Хуудсанд сул зай бага, хоёр хажуугийн шугам нарийхан байна.

• Суралцагч хариулт тэмдэглэл хийх зам хангалттай байна.

• Зураг чимэглэл бага, бичмэл хэсэг нэлээд голлосон байна.

• Зураг чимэглэл, бүдүүвч, хүснэгт, байна.

• Хэнд зориулсан нь тодорхойгүй, хэсэг бүлэгт зориулсан байна.

• Ижил төвшний мэдлэг, чадвар бүхий хэсэг бүлэгт зориулсан байна.

Сайн боловруулсан сурах бичиг, гарын авлага:

1. Суралцагчдын өмнө эзэмшсэн мэдлэг, ажлын туршлага дээр тулгуурлаж гарын авлагыг бичих

2. Суралцагчид сурах арга барилаа хөгжүүлэхэд нь боломжтой байх.

3. Тухайн сургалтын зорилтыг тодорхойлохдоо хувь хүнийг зорилготой ажиллаж сурахад нь туслах.

4. Суралцагчид уг гарын авлагаас шинээр олж авсан мэдлэг, ур чадвараа өөрсдийнхөө ажил, мэргэжилтэй хослуулж хэрэглэх боломжтой байх.

5. Сурах бичиг, гарын авлага нь оюутан, сонсогчид цаашид тухайн салбарын мэдлэгийг гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ төрүүлэхүйц байх.

6. Тухайн сэдвийг уншиж судлах явцад тодорхой асуулт даалгавраар эргэж хариу мэдээлэл авах боломжтой болох.

7. Энэ нь суралцагч өөрсдийн үзэл бодлоо хөгжүүлэх, сонголт хийх бололцоотой байх. Зөвхөн «зөв» эсвэл «буруу» гэсэн хариулт авахаар биш.

8. Бололцоотой газарт нь дадлага ажил хийх боломж өгөх.

9. Материалыг хэт нуршуу биш, товч тодорхой бичих зэрэг болно.

Бие дааж судлах гарын авлагын агуулга, бүтэц ямар байх вэ?

1. Хичээл төвтэй	2. Суралцагч төвтэй
Байгаа сэдвүүддээ тохирох материал олгох	Багш мэргэжилтэй бусад хүмүүсийг оролцуулан шинэ материал боловсруулах.
Нэмэлт болон өөр бусад материалыг олж судалгаа шинжилгээ хийх	Мэдлэг чадвартай багш, эрдэмтдийн туршлагаас судлах
Үндсэн санааг олж анализ шинжилгээ хийх	Суралцагчид өөрсдөө сонголт хийж, түүнийг өдөр тутмын амьдралдаа хэрэглэх
Хичээлийн хэрэгцээ, шаардлагад уялдуулан материалыг бэлтгэх	Оюутан, суралцагчдын хэрэгцээнд тохируулан материалын бүтцийг тодорхойлох

Сурах бичиг, гарын авлагын бүтцийг хэрхэн сонгох вэ?

Дараах хэд хэдэн хувилбараар сонгож болдог. Үүнд:

Цуврал дараалал: Тухайн хичээлийн хөтөлбөрийн дагуу гарын авлагынхаа сэдэв, гарчгуудыг байрлуулж, агуулгын дарааллыг тогтооно.

Шугаман дараарал: Өмнөх мэдээлэл дээр тулгуурлаж шинэ ойлголт өгөхөөр цуваагаар байрлуулна.

Гүнзгийрүүлсэн дараалал: Уг асуудлын гүнд орж өргөтгөсөн, эсвэл өөр хичээлийн агуулгаар өргөтгөсөн байдаг.

Плагиатизмаас зайлсхийх нь (Плагиат – зохиолын хулгай)

Судлаачид заримдаа гадаад эх сурвалжаас санаа авч ашигладаг боловч плагиат үйлдэж байна гэдгээ төдийлөн ухамсарладаггүй. Энгийн



үгээр хэлбэл, хэн нэгэн нь бусад зохиолчдын үг, санааг өөрийн болгон авч хэрэглэвэл плагиат үйлдэж байна гэсэн үг юм. Харин “ерөнхий мэдлэгээс хальсан мэдээ баримт, үг хэллэг болон иш татлалыг ашигласан, үзэл санааг зээлдсэн тохиолдол бүрт эх сурвалжийг тодорхой дурьдсан бол» плагиат үйлдэгдсэн гэж үздэггүй юм байна. (CREWS AND VANSANT, 407)

Гадаад эх сурвалжийг ашиглах талаар ерөнхий зөвлөмж:

Плагиатизмаас зайлсхийх хамгийн шилдэг арга бол өөрийн гаргасан санаа, учир шалтгааныг сайтар хянах явдал юм. Гагцхүү таны өөрийн гаргасан санаанд жин нэмэх тохиолдолд л гадаад эх сурвалжаас бусдын санааг ашиглах хэрэгтэй. Бусад эх сурвалжаас материал ашиглахдаа доорхи зөвлөмжүүдийг байнга санаж бай:

- Сонголтыг анхааралтай хийх. Аливаа иш татлал нь таны гаргаж буй санаанд нэмэр болж баяжуулах ёстой. Өөрөөр хэлбэл, таны санааг давтсан шинж чанартай иш татлалыг сонгон ашиглах хэрэггүй.

- Өөрийнхөө хэлэх гэж буй зүйлд бусад эх сурвалжаас авч хэрэглэсэн санааг бүрэн дүүрэн тусгах шаардлагатай. Иш татлалыг өөрийн үгээр илэрхийлж, тухайн иш татлалын утга санааг тайлбарлах нь зүйтэй.

- Шаардагдах хэмжээнээс илүү их ишлэл ашиглах хэрэггүй. Ихэнхи тохиолдолд ишлэлийг товч байлга.

- Зохиогчийн өвөрмөц үг хэллэг нь онцгой ач холбогдолтой, зайлшгүй шаардлагатай тохиолдолд л түүнийг тэр чигээр нь үг үсэггүй иш татаж болно. Зарим хичээл дээр үг үсэггүй иш татахыг дэмждэггүй тул багштайгаа зөвлөх нь зүйтэй.

- Таны ашиглаж буй материалд өөр нэгэн зохиогчийн иш татлалыг дурьдсан ба танд жинхэнэ эх сурвалж байхгүй тохиолдолд «...-д дурьдагдсанаар...» хэмээн иш татаж болно.

- Шууд иш татлал оруулах тохиолдолд

эх бичгийн доод талд тайлбар хийх төдий нь хангалтгүй юм. Бүх иш татлалыг хашилтанд хийж бичих шаардлагатай. Харин хашилтанд бичигдэх иш татлалыг жинхэнэ эх сурвалжид байгаагийн адил үг үсэггүй үнэн зөв хуулан бичих хэрэгтэй.

- Зарим иш татлалын эх сурвалжийг санамсаргүйгээр орхигдуулахгүйн тулд иш татсан зүйл болгоны эх сурвалжийг ноорог бичигтээ ч мөн оруулж байх нь тустай.

- Ямагт өөрийн санааг сайтар хянаж, түүнийгээ өөрийн үгээр илэрхийлэхийг хичээх нь зүйтэй.

Түгээмэл алдаа: тэмдэглэл хөтлөх үе шат

Плагиатизм нь ихэнхдээ судалгаа шинжилгээний явцын тэмдэглэл хөтлөх үе шатанд эхэлдэг. Иймд, хэрэв боломжтой бол номын санд очихын өмнө өөртөө тодорхой зорилго тавьснаар хэт их дэлгэрэнгүй тэмдэглэл хийн цаг гарздахааас урьдчилан сэргийлж болох юм. Тэмдэглэл хөтлөх явцад номноос авсан санааг өөрийн үгээр илэрхийлэх, шууд иш татах хоёрыг хооронд нь ялган ойлгох нь чухал. Шууд иш татан хуулах тохиолдолд тун нягт нямбай байх хэрэгтэй. Тухайн иш татлалтай холбоотой бүхий л мэдээллийг тэмдэглэн авч иш татаж буй зүйлийг яг эх бичигт байгаагийн адил алдаа мадаггүй хуулан бичнэ. Зарим зохиолчид тэмдэглэл хөтлөхдөө зөвхөн шууд иш татлал авч ашигладаг ба тэд бусдын санааг өөрийн үгээр илэрхийлсэн тэмдэглэл, шууд иш татлал хоёрын хоорондох ялгааг ойлгодог. Бас нэг хэсэг зохиолчид нь шууд иш татсан зүйлээ нэг өнгөөр тэмдэглээд, бусдын санааг өөрийн үгээр илэрхийлсэн хэсгийг өөр өнгөөр тэмдэглэн ялгадаг. Бусдын санааг өөрийн үгээр илэрхийлэн тэмдэглэхдээ эх сурвалж материалыг судлан уншсан даруй цааш нь тавьж зөвхөн өөрийн үгээр бичих нь зүйтэй. Ингэснээр зарим үг хэллэг, өгүүлбэрийг тэр чигээр нь хуулахаас зайлсхийж болох

юм. Дүгнэн хэлэхэд, тэмдэглэл хөтлөх арга ажиллагаанд тун туйлбартай, ухамсартай хандах хэрэгтэй.

Жишээ:

Зарим үед зохиолчид бусдын санааг авч ашигласнаар плагиатизм үйлдэж байна гэдгийг төдийлөн ухамсарладаггүй. Доор үзүүлсэн хувилбаруудад плагиатизм ба эх сурвалжид байгаа санааг өөрийн үгээр илэрхийлэх хоёрын хоорондох ялгааг үзүүлсэн болно.

Эх сурвалж

Дохио зангаагаар харилцаж чаддаг сармагчин байдаг нь хэл судлаачдын хувьд тайлбарлахад хэцүү зүйл байсан бол амьтан судлаачдын хувьд ч энэ нь гайхалтай мэдээ болсон юм. (Davis, 26)

"А" хувилбар

Дохио зангаагаар харилцаж чаддаг сармагчин байдаг нь хэл судлаачдыг тэвдүүлж, амьтан судлаачдыг гайхшруулжээ. (Davis, 26)

Тайлбар:

Энэ бол плагиатизм. Эх сурвалжийг нэрлэсэн боловч бичигч нь шууд иш татлал болох «дохио зангаагаар харилцаж чаддаг сармагчин байдаг нь гэсэн хэсгийг хашилтанд оруулаагүй. Үүнээс гадна «хэл судлаачдыг тэвдүүлж, амьтан судлаачдыг гайхшруулжээ» гэсэн хэсэг нь жинхэнэ эх сурвалжийн үг хэллэгтэй тун адилхан сонсогдож байна.

"Б" хувилбар

Дохио зангааны хэл ашиглан харьцаж чаддаг мич байдаг нь хэл судлаач эрдэмтдийн санааг зовоохын зэрэгцээ амьтдын зан байдлыг судалдаг эрдэмтдийн хувьд санамсаргүй явдал байжээ. (Davis, 26)

Тайлбар:

Мөн л плагиатизм үйлдсэн гэж үзнэ. Бичигч нь эх сурвалжийг нэрлэж, утга адил үгс хэрэглэсэн

хэдий ч плагиатизм үйлдсэн, учир нь жинхэнэ зохиогчийн өгүүлбэрийн бүтцийг өөрчлөлгүй хэвээр нь авч ашигласан байна.

"В" хувилбар

Флора Дэйвисийн бичиж байгаагаар, сургагч нартайгаа дохио зангаагаар харилцаж чаддаг мич байдаг тухай мэдээ нь хэл судлаачид болон амьтны зан байдал судлаачдыг тэвдүүлжээ. (Davis, 26)

Тайлбар:

Плагиатизм үйлдсэн гэж тооцохгүй. Жинхэнэ эх сурвалжаас авсан мэдээллийг өөрийн үгээр тохиромжтой илэрхийлсэн байна.

Төгсгөл

Эрдэм шинжилгээний явцад бусдын санааг ашиглан өөрийн судалгаанд жин нэмж сурах нь дээд боловсролын хүрээнд үнэнч шударга байх явдал ба тодорхой чармайлт гарган хариуцлага хүлээхийг шаарддаг. Яг хэзээ, ямар тохиолдолд эх сурвалжийг ашиглах нь зүйтэй вэ гэдэг асуулт тодорхойгүй байдаг тул заримдаа танд зөвлөмж шаардагдах нь гарцаагүй. Профессор багш нар тань өөрийн зааж буй хичээлийн хүрээнд ямар зүйл шаардагдах тухай маш сайн ойлголттой хүмүүс тул тэдэнд хандах нь хамгийн оновчтой болов уу. Мөн англи хэл дээрх доорх сурах бичгийг эх сурвалж болгон ашиглаж болно.

1.Crews, Frederick and Ann Jessie Van-sant. The Random House Handbook, 4th edition. New York: Random House, 1984.

2.Fowler, H.Ramsey and Jane Aajon. The Little, Broun Handbook. Glenview, Ill.: Scott, Foresman and Co., 1989.

3.Hacker, Diana. The Bedford Hand-book for Writers. Boston: St.Martin's Press, 1991.

4.Hacker, Diana. A Pocket Style Man-ual. New York: Bedford Books of St.Mar-tin's Press, 1993.

5.Trimmer, Joseph. A Guide to MLA Documentation. Boston: Houghton Miff-lin, 1989.

Сурах бичиг, гарын авлагын чанарыг



сайжруулахтай холбоотой дараах саналууд байна.

-Хэвлэл редакцын хэлтэс байгуулагдаж сургууль дээр гарч буй ном, сурах бичиг, гарын авлагад үнэлэлт дүгнэлт өгч, хэвлэх, сургалтад ашиглах зөвшөөрөл олгож байгааг зөв зүйтэй чухал ажил гэж ойлгож байгаа. Энэ ажил ирүүлж буй бүтээлийн чанар, чансаанаас эхлээд эхнээсээ хүндрэл бэрхшээлтэй учирч байгаа гэдгийг ч сонссон.

-Ер нь ёс зүй, философи, түүх, менежмент, гадаад хэл, компьютер, галын бэлтгэл зэрэг нэгэнт судлаад тогтчихсон, бид нэг ч үг өгүүлбэр, томъёолол, тодорхойлолт, деталь, нэр томъёо шинээр нэмж зохион бичих боломжгүй чиглэлээр сурах бичиг, ном бичихийг хязгаарлаж, тухайн чиглэлээр хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтдийн бүтээлийг сонгон худалдаж авах нь үр дүнтэй юм.

-Хэвлэл редакцын албанд салбар салбарын хүлээн зөвшөөрөгдсөн судлаач, эрдэмтдээс шинжээчээр татан оролцуулах шаардлагатай.

-Бүтээлийг үнэлэх шалгуур үзүүлэлт бол ус агаар мэт хэрэгтэй зүйл шүү. Манайд одоогоор байхгүй юм болов уу? Би л лав олж хараагүй.

-Боловсруулж батлуулсан, нийтээр дагаж мөрдөх эрдэм шинжилгээ, сургалтын журам, стандартууд техникийн болон технологийн ноцтой алдаатай, Монгол Улс, дэлхийн стандарт жишгээс ухарсан байгааг залруулах нь зүйтэй. Тухайлбал:

1.Магистрын ажил бичих шаардлага, стандартад ишлэл авсан бүтээлийг бүтээлийн нэргүйгээр зөвхөн зохиогчийн нэр, хэвлэгдсэн он, хуудас байхаар "Ц.Дорж, Б.Бат. 2015 он. УБ. 15хх" гэх мэтээр заасныг нь мань мэт бол техникийн алдаа гэж уучлан ойлгох ч эрхэм магистрантууд энэ хэвээр нь ойлгож, бичиж байгааг уучлах аргагүй юм.

2.Магистрант, докторантуудын

бичсэн өгүүллэгийг нийтлэх зөвшөөрөл олгосон сэтгүүлүүдийн жагсаалт гаргажээ. Харамсалтай нь, Монголын Хил Судлалын Академи, Хилийн сургуулийн эрхлэн гаргадаг 921 тоот улсын бүртгэлийн дугаартай, 14921 тоот индекстэй, DDC 355.02 Г-21 кодтой, 978-99973-41-65-5 ISBN дугаар бүхий 19 дэх жилдээ улирал бүр 10-17 хэвлэлийн хуудастайгаар В-7 форматаар 300-1000 хувь хэвлэгдэн 45 дах дугаараа гарган хилчдийн оюуны хэрэгцээг хангаж буй онол-мэдээллийн, миний эрхлэгчээр нь ажилладаг "Хил судлал" сэтгүүл багтсангүйд ихэд харамсаж байгаагаа илэрхийлэхийн ялдамд "Хил судлал" сэтгүүл шиг улсын бүртгэл, индекстэй, кодтой, хууль ёсны зөвшөөрөлтэй сэтгүүл сургууль дээр байхгүй болой. Мэргэн түшмэдүүд анхааралдаа авна гэдэгт найдъя.

3.Сургууль дээр хамгаалсан болон хамгаалж буй магистр, докторын ажлуудыг цахим санд бүртгэж, хамгаалахын өмнө "зохиолын хулгайн" программаар уншуулж, ишлэл авсан, бусдын бүтээлээс хуулбарласан зохистой харьцааг болон нууцын зэргийг тогтоож байх нь зүйтэй бөгөөд "Плагиат" программыг хэрэглээнд нэвтрүүлэх зайлшгүй шаардлага байна.

Зохиолын хулгайтай холбоотой асуудлаар сургуулийн докторуудын хоорондох гурван ч удаагийн томоохон маргааны гэрч, шинжээч болж байсны хувьд энэ мэт маргаан үргэлжлэн гарах өндөр эрсдэл байгаагаас сэрэмжлүүлэх гэсэн юм.

Номын цагаан буян ивээх болтугай.